



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Г Өсвөр үеийн эрүүл мэндийн
мэдээллийн маягт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн, Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийн маягтыг нэгдүгээр, өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийн маягтыг хөтлөх зааварчлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан маягтын дагуу өсвөр үеийнхний эрүүл мэндийн мэдээллийг сар бүрийн эхний долоо хоногийн Даваа гаригт Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, мэдээллийг нэгтгэн улирал бүрийн эхний долоо хоногт Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж байхыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр)-д, хагас жил тутамд мэдээллийг Эрүүл мэнд, спортын яаманд хүргүүлж байхыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

3. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн нэгдсэн үзүүлэлтэд дүгнэлт хийж, хагас жил тутам Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлд танилцуулж байхыг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн) – т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Ганчимэгт даалгасугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
06 дугаар сарын 05-ны өдрийн 02/У дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт.

Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийн маягт

Бүртгэлийн дугаар		1. Ерөнхий асуулга													Алхам		
№	Асуулт	Хариултын код															
1	Үзлэг эхэлсэн он, сар, өдөр, цаг, минут	о	о	о	о	о	о	с	с	с	ө	ө	ц	ц	м	м	
2	Регистрийн дугаар	у	у	у	у	у	у	т	т	т	т	т	т	т	т		
3	Нас																
4	Хүйс	Эрэгтэй Эмэгтэй Тодорхойгүй											1 2 3				
5	Үндсэн хаяг (аймаг, хот, сум дүүрэг, баг, хороо)																
6	Энд ирэхийг хэн санал болгосон бэ?	Өөрийн хүсэлтээр Гэр бүлийнхний хүсэлтээр ирсэн эсэх Үе тэнгийнхэн зөвлөснөөр Бусад эмнэлгээс шилжин ирсэн эсэх Бусад байгууллагаас (эмнэлгээс бусад) шилжин ирсэн эсэх											1 2 3 4 5				
7	Гэрэлсэн эсэх	Тийм Үгүй											1 2				
7а	Тийм бол гэр бүлийн байдал	Хамтран амьдрагч Гэрлэсэн Гэрлэсэн/гусдаа Салсан Бусад											1 2 3 4 5				
8	Хөдөлмөр эрхэлдэг эсэх	Тийм Үгүй											1 2				
9	Сургуульд сурдаг эсэх	Тийм											1 → 9а				



	Угүй	2	10
	Их, дээд сургууль	1	
	Коллеж	2	
	Мэргэжлийн ба техникийн сургууль	3	
	Ерөнхий боловсролын сургууль	4	
	Албан бус сургалт	5	
	Асрамж, халамжийн төвүүд	6	

2. Асуумж/анамнез

10	Өмнө нь жирэмсэлж байсан эсэх	Тийм	1	10a
10a	Жирэмсэлж байсан бол хэдэн удаа	Үгүй	2	11
10b	Өмнө нь үр хөндөлт хийлгэж байсан эсэх	Тийм	1	10c
10b	Өмнө нь үр хөндөлт хийлгэж байсан эсэх	Үгүй	2	10d
10c	Хийлгэж байсан бол үр хөндөлт хийлгэсэн үеийн тээлтгүйн хугацаа			
10d	Өмнө нь төрж байсан эсэх	Тийм	1	10e
10d	Өмнө нь төрж байсан эсэх	Үгүй	2	11
10e	Төрж байсан бол хэдэн удаа			
11	Өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан уу?	Тийм	1	11a
11	Өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан уу?	Үгүй	2	12
11a	Тийм бол ямар БЗДХ-аар өвдөж байсан бэ?	Тэмбүү	1	
11a	Тийм бол ямар БЗДХ-аар өвдөж байсан бэ?	Заг хүйтэн	2	
11a	Тийм бол ямар БЗДХ-аар өвдөж байсан бэ?	Трихомоноиаз	3	
11a	Тийм бол ямар БЗДХ-аар өвдөж байсан бэ?	Бусад (нэрлэж бичнэ үү)	4	
11b	БЗДХ-аар өвдсөн бол эмчлүүлж байсан эсэх	Тийм	1	


		Үгүй	2
12	Ямар нэгэн хорт зуршилтай эсэх	Тийм	1 → 12a
		Үгүй	2 → 13
12a	Тийм бол ямар хорт зуршилтай вэ?	Мансууруулах төрлийн бодис	1
		Тамхи	2
		Архи, согтууруулах ундаа	3
		Компьютер, утсанд донтсон	4
		Бусад (нэрлэж бичнэ үү)	5
13	Өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан эсэх	Тийм	1 → 13a
		Үгүй	2 → 14
13a	Тийм бол ямар төрлийн хүчирхийлэлд вэ?	Бэлгийн хүчирхийлэл	1
		Бие махбодийн хүчирхийлэл	2
		Сэтгэл санааны хүчирхийлэл	3
		Ул хайхрах хүчирхийлэл	4
13b	Хүчирхийлэлд өртсөн орчин	Гэр бүлийн хүчирхийлэл	1
		Бусад орчинд (нэрлэж бичнэ үү)	2
14	Өмнө нь сэтгэцийн эмгэг оношилогдож байсан эсэх	Тийм	1
		Үгүй	2
15	Өмнө нь осол, гэмтэлд өртөж байсан эсэх	Тийм	1
		Үгүй	2
3. Үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал / бодит үзлэгээр /			
16	Биеийн жин		
17	Биеийн өндөр		
18	Жирэмсэн эсэх (сорил, шинжилгээгээр батлагдсан байх)	Тийм	1 → 18a
		Үгүй	2 → 19
18a	Тийм бол жирэмснийг хэрхэн шийдвэрлэсэн	Зөвлөгөө	1

бэ?	Шилжүүлсэн	2	
	Бусад (нэрлэж бичнэ үү)	3	
19 БЗДХ оношилогдсон эсэх (сорил шинжилгээгээр батлагдсан байх)	Тийм	1	19a
	Үгүй	2	20
	Тэмбүү	1	
	Заг хүйтэн	2	
19a Тийм бол ямар БЗДХ оношилогдсон бэ?	Трихомониаз	3	
	Бусад (нэрлэж бичнэ үү)	4	
	Зөвлөгөө	1	
	Эмчилгээ	2	
19b БЗДХ-ны менежмент	Шилжүүлсэн	3	
	Давтан үзлэг товлосон	4	
	Давтан эмчилгээ/хяналт	5	
	Тийм	1	
20 Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгсөн эсэх	Үгүй	2	
	Гетеросекс	1	
21 Бэлгийн чиг хандлага (нэрлэж бичнэ үү)	Гомосекс	2	
	Трансжендер	3	
	Бусад	4	
	Мэдэхгүй	5	
	Хариулахыг хүсэхгүй	6	
	Тийм	1	22a
22 Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал сэжиглэгдсэн/оношилогдсон эсэх	Үгүй	2	23
	Зөвлөгөө	1	
22a Тийм бол сэтгэцийн эрүүл мэндийн менежмент	Эмчилгээ	2	
	Дээд шатлал руу шилжүүлсэн	3	
	Давтан үзлэг товлосон	4	

		Нийгмийн ажилтан/сэтгэлзүйч рүү шилжүүлсэн										5	
23	Хүчирхийлэлд өртсөн эсэх	Тийм Үгүй										1 → 23a	
23a	Тийм бол ямар төрлийн хүчирхийлэл вэ?	Бэлгийн хүчирхийлэл Бие махбодийн хүчирхийлэл Сэтгэл санааны хүчирхийлэл Үл хайхрах хүчирхийлэл Гэр бүлийн хүчирхийлэл Бусад орчинд (нэрлэж бичнэ үү)										1 2 3 4 1 2	
23b	Хүчирхийлэлд өртсөн орчин	Зөвлөгөө Эмчилгээ										1 2	
23c	Тийм бол ямар менежмент хийсэн бэ?	Дээд шатлал руу шилжүүлсэн Давтан үзлэг товлосон Нийгмийн ажилтан руу шилжүүлсэн Бусад (нэрлэж бичнэ үү)										3 4 5 6	
24	Үзлэг дууссан он, сар, өдөр, цаг, минут	о	о	о	о	с	с	ө	ө	ц	ц	м	м
Үйлчилгээний төрөл (байгууллага харцуулна)													
		10-аас доош нас											
1	Өсвөр үеийн клиникээр үйлчлүүлсэн өсвөр үеийнхний тоо	10-19 нас											
2	НҮЭМ-ийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо	20-24 нас											
3	Сэтгэл зүйн тусламж авсан өсвөр үеийнхний тоо												
4	Нийгмийн ажлын тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоо												
5	Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн чиглэлээр тэдэнд зохион байгуулсан сургалтын тоо												
6	ЭМ-ийн чиглэлээр зохион байгуулсан сургалтанд хамрагдсан хүний тоо												
7	ЭМ-ийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо												
8	Өсвөр үеийн баримжаа олгох сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо												
9	Өсвөр үеийн төрөлжсөн тусламж үйлчилгээний сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо												
10	2, 3 дах шатлалын эмнэлэг рүү илгээсэн үйлчлүүлэгчийн тоо												
Мэдээлсэн их эмчийн нэр.....													
Мэдээлсэн он сар өдөр.....													

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны
06 дугаар сарын 05-ны өдрийн 229 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт.

Өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзүүлэлтийн маягтыг
хөтлөх зааварчилгаа



Ерөнхий асуулга

Ерөнхий асуулгын зорилго нь өсвөр үе, залуучуудын талаарх ерөнхий мэдээллийг үнэн зөв, бодитой цуглуулахад оршино.

Асуулт 1: Тухайн эмч үзлэг хийсэн он, сар, өдөр, цаг, минутаа бичнэ. Жишээ: Нүд бүрт нэг тоо бичнэ.

2	0	1	5	0	6	0	8	1	3	3	0
---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---

(2015 оны 6 сарын 8-ны 13 цаг 30 минут гэсэн үг)

Асуулт 2: Регистрийн дугаарыг бөглөхдөө үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. Жишээ нь:

A	H	9	4	1	2	2	4	6	5
---	---	---	---	---	---	---	---	---	---

Асуулт 3: Нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд үйлчлүүлэгчийн төрсөн он, сарыг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ нь: 15 настай бол

1	5
---	---

 гэж тэмдэглэнэ.

Асуулт 4: Үйлчлүүлэгчийн хүйсийг мэдээлэхдээ эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хүйс тодорхойгүй бол-3 гэсэн кодыг сонгоно.

Асуулт 5: Үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо зэргийг гаргацтай бичнэ.

Асуулт 6: Эмнэлэгт хэний хүсэлтээр ирсэн болохыг сонгоно.

Асуулт 7: Үйлчлүүлэгч гэрлэсэн эсэхийг тийм бол-1, үгүй бол-2 гэж сонгоно. Гэр бүлтэй гэж хариулсан бол асуулт 7а руу шилжинэ. Үгүй гэж хариулсан бол асуулт 8 руу шилжинэ.

Асуулт 8: Үйлчлүүлэгч ажил хөдөлмөр эрхэлдэг эсэхийг тийм бол-1, үгүй бол-2 гэж сонгоно.

Асуулт 9: Үйлчлүүлэгч сургуульд сурч байгаа эсэхийг хариултаас сонгоно: Хэрэв сурдаг бол ямар сургуульд сурдаг болохыг асуулт 9а-аас сонгоно. Сурдаггүй бол асуулт 10 руу шилжинэ.

Асуумж/анамнез

Үйлчлүүлэгчид өмнө нь ямар асуудал тулгарч байсныг асууж бөглөнө.

Асуулт 10: Үйлчлүүлэгч өмнө нь жирэмсэлж байсан эсэхийг сонгоно. Тийм гэж сонгосон бол асуулт 10а-10е-д хариулна. Үгүй гэдгийг сонгосон бол асуулт 11-т хариулна.

Асуулт 10а: Өмнө нь хэдэн удаа жирэмсэлж байсан болохыг тоогоор бичнэ. Одоо жирэмслэлтийг оруулахгүй. Өмнө нь 2 удаа жирэмсэлж байсан бол гэж тэмдэглэнэ.

0 2

Асуулт 10b: Өмнө нь үр хөндөлт хийлгэж байсан эсэхийг тохирох хариултаас сонгоно. Хэрэв тийм гэж хариулсан бол асуулт 10с рүү шилжинэ. Үгүй гэсэн бол асуулт 10d рүү шилжинэ.

Асуулт 10с: Үр хөндөлт хийлгэж байсан жирэмсний хэдэн долоо хоногтойд үр хөндөлт хийлгэсэн болохыг бичнэ. Өмнө нь 2 удаа үр хөндөлт хийлгэж байсан бол хамгийн сүүлд хийлгэсэн үр хөндөлтийн тээлтийн долоо хоногийг бичнэ. Жирэмсний 4 долоо хоногтойд үр хөндөлт хийлгэсэн бол 0 4 гэж тэмдэглэнэ.

Асуулт 10d: Өмнө нь төрж байсан эсэхийг тохирох хариултаас сонгож тэмдэглэнэ. Тийм гэсэн хариулт сонгосон бол асуулт 10е-д хариулна. Үгүй гэсэн хариулт сонгосон бол асуулт 11 рүү шилжинэ.

Асуулт 10е: Өмнө нь төрж байсан бол хэдэн удаа төрсөн болохыг тоогоор бичнэ. Өмнө нь 1 удаа төрсөн бол 0 1 гэж тэмдэглэнэ.

Асуулт 11: Өмнө нь бэлгийн замаар дамжих халдвар оношилогдож, эмчлэгдэж байсан эсэхийг хариултаас сонгоно. Тийм бол асуулт 11а руу цааш хариулна. Үгүй бол асуулт 12 руу үсэрнэ.

Асуулт 11а: БЗДХ-аар өвдөж байсан бол аль нь илэрсэн болохыг тохирох хариултаас сонгоно. Олон хариулт сонгож болно. Мөн бусад гэсэн хариултыг сонгосон бол дэлгэрүүлж бичнэ.

Асуулт 11b: Өмнө нь оношилогдсон БЗДХ-ыг эмчлүүлж байсан эсэхийг сонгоно.

Асуулт 12: Үйлчлүүлэгч мансууруулах бодис буюу бусад хорт зуршилтай эсэхийг тохирох хариултаас сонгоно. Тийм бол ямар төрлийн зуршилтай болохыг асуулт 12а-аас сонгоно. Үгүй бол асуулт 13 руу үсэрнэ.

Асуулт 12а: Үйлчлүүлэгч ямар төрлийн хорт зуршилтай болохыг хариултаас сонгоно. Бусад гэсэн хариултыг сонгосон бол дэлгэрүүлж бичнэ. Олон хариулт сонгож болно.


Асуулт 13: Үйлчлүүлэгч өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг хариултаас сонгоно. Хүчирхийлэлд өртөж байсан бол асуулт 13а-д хариулна, үгүй бол асуулт 14-т хариулна.

Асуулт 13а: Хүчирхийлэлд өртөж байсан бол ямар хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан болохыг хариултаас сонгоно. Олон хариулт сонгож болно.

Асуулт 13b: Хүчирхийлэлд хаана өртөж байсан болохыг тохирох хариултаас сонгоно. Бусад орчинг сонгосон бол дэлгэрүүлж бичнэ.

Асуулт 14: Өмнө нь үйлчлүүлэгчид сэтгэцийн ямар нэгэн эмгэг оношилогдож, эмчлэгдэж байсан бол тохирох хариултаас сонгоно.

Асуулт 15: Үйлчлүүлэгч өмнө нь ямар нэгэн осол, гэмтэлд өртөж байсан бол тохирох хариултаас сонгоно.



Үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал

Үйлчлүүлэгчид тулгамдсан асуудлыг үзлэг хийж буй явцдаа эмч өөрөө бөглөнө.

Асуулт 16: Үзлэг хийх үед биеийн жинг хэмжиж, бөглөнө /кг-аар/.

Асуулт 17: Үзлэг хийх үед биеийн өндрийг хэмжиж бөглөнө /см-ээр/.

Асуулт 18: Үйлчлүүлэгч одоо жирэмсэн байгаа эсэхийг сорил, шинжилгээг харж сонгоно. Тийм гэж сонгосон бол асуулт 18а-д хариулна. Үгүй гэдгийг сонгосон бол асуулт 19-д хариулна.

Асуулт 18а: Жирэмсэн эхийн жирэмслэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тохирох хариултаас сонгоно. Бусад гэсэн хариултыг сонгосон хариултыг дэлгэрүүлж бичнэ.

Асуулт 19: Үзлэгийн явцад бэлгийн замаар дамжих халдвар илэрсэн эсэхийг сорил, шинжилгээг үндэслэн хариултаас сонгоно. Илэрсэн бол асуулт 19а руу цааш хариулна. Илрээгүй бол асуулт 20 руу үсэрнэ.

Асуулт 19а: БЗДХ илэрсэн бол аль нь илэрсэн болохыг тохирох хариултаас сонгоно. Бусад гэсэн хариултыг сонгосон бол хариултыг дэлгэрэнгүй бичнэ. Олон хариулт сонгож болно.

Асуулт 19b: Үйлчлүүлэгчийн БЗДХ-т ямар менежмент хийснээ тухайн эмч сонгоно. Олон хариулт сонгож болно.

Асуулт 20: Эмч үйлчлүүлэгчид гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгсөн бол тийм -1, зөвлөгөө өгөөгүй бол үгүй -2 гэсэн хариултыг сонгоно.

Асуулт 21: Үйлчлүүлэгчийн бэлгийн чиг хандлагыг асууж, тохирох хариултаас сонгож тэмдэглэнэ.

Асуулт 22: Үйлчлүүлэгчид сэтгэцийн ямар нэгэн эмгэг сэжиглэж байгаа буюу оношилж байгаа бол тохирох хариултаас сонгоно. Тийм бол асуулт 22а руу шилжинэ. Үгүй бол асуулт 23 руу үсэрнэ.

Асуулт 22а: Тухайн сэжиглэсэн сэтгэцийн эмгэгийн дагуу ямар менежмент хийсэн болохыг тохирох хариултаас сонгоно. Олон хариулт сонгож болно.

Асуулт 23: Үйлчлүүлэгч танд үзүүлэхээр ирэхдээ хүчирхийлэлд өртсөн байгаа эсэхийг хариултаас сонгоно. Хүчирхийлэлд өртсөн байгаа бол асуулт 23а-д хариулна.

Асуулт 23а: Хүчирхийлэлд өртсөн байгаа бол ямар хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн болохыг хариултаас сонгоно. Олон хариулт сонгож болно.

Асуулт 23b: Хүчирхийлэлд хаана өртсөн болохыг тохирох хариултаас сонгоно. Бусад орчинг сонгосон бол хариултыг дэлгэрэнгүй бичнэ.

Асуулт 23с: Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд ямар тусламж үзүүлсэн болохыг тохирох хариултаас сонгоно. Бусад гэсэн хариултыг сонгосон бол хариултыг дэлгэрэнгүй бичнэ. Олон хариулт сонгож болно.

Асуулт 24: Үзлэг дууссан он, сар, өдөр, цаг, минутыг тухайн нүдэнд тохируулж бичнэ.

Үйлчилгээний төрөл

Үйлчилгээний төрөл асуумжийг тухайн эмнэлгийн байгууллага сард 1 удаа нэгтгэсэн тоон дүнгээр явуулна.